



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Төсөв батлах тухай” 06 дугаар тогтоолын дагуу тус сургуулийн албан хэрэгцээнд зориулан нийт 7,049,071,900.00 (долоон тэрбум дөчин есөн сая далан нэгэн мянга есөн зуун) төгрөгт багтаан хавсралтад заасан төсөл арга хэмжээг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх замаар үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Мандах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000143

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн
.....Н.Д.... дугаар тогтоолын хавсралт



Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 онд
хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
		(мян.төгрөг)
	Барилга байгууламж	
1	МУБИС-ын Ерөнхий боловсролын сургуульд өргөтгөлийн давхар нэмж барих	800,000.0
2	Оюутны хөгжил, хээрийн дадлагын бааз шинээр байгуулах	2,500,000.0
3	НХУС-ийн гадна фасад усны хоолойн засвар /Б байр/	80,000.0
4	БТС-ийн 106, 107 заалны дээврийн засвар	80,000.0
5	БС, ЕБС-ийн номын сангийн засвар	75,000.0
6	МБУС-ийн 122, 123 тоот лекцийн заалны дээврийн засвар	15,000.0
7	Оюутны 4-р байрны өрөө тасалгаа, нийтийн эзэмшлийн талбайн засвар	80,000.0
8	Ерөнхий боловсролын сургуулийн зоорийн давхрын засвар	75,000.0
9	МБУС-д цахилгаан шат шинээр угсрах	195,000.0
10	Хичээлийн 1-р байрны спорт заалны шал хусаж, лагдах ажил	16,000.0
Бүгд дүн		3,916,000.0
	Тээврийн хэрэгсэл	
11	Суудлын автомашин 1 ширхэг, 9-12 хүний суудалтай, хөдөлгүүрийн багтаамж 2700сс хүртэл, улсын дугаар аваагүй, /Архангайн Багшийн сургууль/	29,000.0
12	Бага оврын автобус 1 ширхэг, 9-12 хүний суудалтай, хөдөлгүүрийн багтаамж 2700сс хүртэл, улсын дугаар аваагүй, (МУБИС-Захиргаа)	35,000.0
Бүгд дүн		64,000.0
13	Тоног төхөөрөмжийн бүгд дүн	2,470,478.2
14	Тавилга эд хогшлийн бүгд дүн	598,593.7
Нийт дүн		7,049,071.9
		(долоон тэрбум дөчин есөн сая далан нэгэн мянга есөн зуун)